



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ 13

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2025 оны 12 дугаар сарын 03 наас 2026 оны 1 дүгээр сарын 7 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Өвчний сэжигтэй, өвчилсөн шувууд бүртгэгдсэн үед: ЗӨСҮТ-н 70282853 дугаарт мэдээлэл өгөх эсвэл дараах холбоосоор мэдээлэл илгээнэ үү. <https://arcg.is/KXDjy>

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2025 оны 12 дугаар сарын 03 наас 2026 оны 1 дүгээр сарын 7 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2003 оноос 2025 оны хооронд хүний өвчлөлийн 992 тохиолдол 25 улс оронд бүртгэгдсэн ба үүнээс 475 хүн нас барсан.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2025 оны 12 дугаар сарын 03 наас 2026 оны 1 дүгээр сарын 7 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Австри, АНУ, Бельги, Бразил, Канад, Чех, Финланд, Вьетнам, Өмнөд Солонгос, Дани, Испани, Португал, Унгар, Норвеги, Өмнөд Африк, Их Британи, Герман, Итали, Унгар, Ирак, Словени, Словаки, Намиби зэрэг 38 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 719 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Ихэвчлэн Зүүн Ази, Европ тивийн улс оронд нүүдлийн шувуудад өвчлөл бүртгэгдсэн.


Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	АНУ	Шувууны аж ахуй	14
H5N1	Австри	Цахлай, элээ, нугас, начин шонхор, сар шувуу, шар шувуу	15
H5N1, H5	Бельги	Тогоруу, шилийн сар, зээрд нугас, галуу, шар шувуу, тагтаа, дэглий,	11
H5N1	Бразил	Шувууны аж ахуй	1
H5N1	Болгар	Тодорхойгүй	1
H5N1	Канад	Шувууны аж ахуй	7
H5N1	Колумб	Шувууны аж ахуй	8
H5N1	Чех	Бор галуу, Хун, шувууны аж ахуй	14
H5N1	Дани	Шувууны аж ахуй, тогоруу, шилийн	41

		сар, зээрд нугас, галуу, хэрээ, цахлай, харцага	
H5N1	Эстони	Хун, цагаан сүүлт бүргэд	5
H5N1	Финланд	Хун, гангар хун	6
H5N1	Франц	Шувууны аж ахуй	25
H5N1	Герман	Галуу, нугас, шувууны аж ахуй	145
H5N1	Унгар	Цахлай дэглий	3
H5N1	Ирак	Шувууны аж ахуй	1
H5N1	Ирланд	Хун	2
H5N1	Энэтхэг	Тодорхойгүй	1
H5N1	Итали	Нугас, галуу, цахлай, шувууны аж ахуй	26
H5N1	Япон	Харцага, шувууны аж ахуй, хун, нугас, орчны шинжилгээ, тогоруу	35
H5N1	Норвеги	Хун, цахлай	9
H5N1	Польш	Шувууны аж ахуй, хун, цахлай	49
H5N1, H5	Португал	Шувууны аж ахуй, цахлай, эргийн шувуу	14
H5N1	Латви	Шувууны аж ахуй	2
H5N1	Словак	Хун, шар шувуу	4
H5N1	Словени	Хун, дэглий	4
H5N1, H5	Өмнөд Солонгос	Шувууны аж ахуй, орчны сорьц	18
H5N1	Өмнөд Африк	Эгэл хараалай	1
H5N1	Испани	Шувууны аж ахуй, гогой, тогоруу, нугас, галуу, өрөвтас, цахлай	14
H5N1	Швед	Шувууны аж ахуй, эргийн шувуу цахлай, галуу	27
H5N1	Швейцар	Шумбуур, цахлай	3
H5N1	Тайвань	Шувууны аж ахуй, халбаган хошуут	5
H5N1	Их Британи	Шувууны аж ахуй, галуу, хараалж, цахлай, шонхор, харцага, тураг гогой	137
H5N1	Нидерланд	Шувууны аж ахуй, шонхор, хун, өрөвтас, нугас	40
H5	Вьетнам	Шувууны аж ахуй, нугас	2
H5	Намиби	Хараалай	2
H5N1	Люгсембург	Нугас	4

Зураг 1. 2025 оны 12 дугаар сарын 03 наас 2026 оны 1 дүгээр сарын 7 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



Нүүдлийн шувуудаа хайрлаж
Тэжээвэр шувуудаа хашиж

Хамгаалъя!!